

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Дээд боловсролын тухай хууль, БСШУЯ-ны Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам, МУИС-ийн дүрмийг үндэслэн МУИС-ийн Төгсөлтийн дараах сургууль (ТДС)-ийн үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, профессор багш, ажилтан, оюутны мэргэжлийн мэдлэг, ур чадварт тавих шаардлага, хэрэгжилтийг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2 МУИС-ийн Төгсөлтийн дараах сургуулийн сургалтын журмыг (цаашид “журам” гэнэ) МУИС-ийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж, захирлын тушаалаар баталж мөрдөнө.

1.3 Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал ТДС-ийн захирал ТДС-ийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрийг МУИС-ийн захиргааны зөвлөлд уламжлан, захирлын тушаал гаргуулж шийдвэрлэнэ.

1.4 ТДС-ийн сургалтын зорилго нь байгаль, нийгэм, хүмүүнлэг, инженер, технологийн мэргэжлээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, инновацын хүрээнд мэргэжлийн өндөр боловсрол эзэмшсэн, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, өөрийгөө нээж хөгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадал, ёс зүйг эзэмшсэн магистр, докторын зэрэгтэй мэргэжилтэн, судлаач бэлтгэхэд оршино.

1.5 Магистрын зэрэг хамгаалагч нь эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх чадвар, докторын зэрэг хамгаалагч нь бие даан судалгаа хийж, эрдэм шинжилгээний ажлыг удирдах чадвар эзэмшсэн байна.

Хоёр. Үйл ажиллагааны чиг, үүрэг

2.1 ТДС нь МУИС-ийн дүрмийн дагуу байгуулсан МУИС-ийн үндсэн нэгж бөгөөд ТДС-ийн сургалт, судалгаа, профессор, оюутны болон санхүүгийн үйл ажиллагаанд чанарын хяналт тавьж, удирдлагаар хангах үүрэгтэй.

2.2 ТДС нь дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.1 Сургалтын үйл ажиллагааны хүрээнд магистр, докторын сургалтын хөтөлбөр шинээр нээх, хаах, оюутан элсүүлэх, кредит цагийн биелэлт, чанарт хяналт тавих, оюутан төгсгөх, сургалтын ассистантшип (бакалаврын сургалтанд оролцуулж цалин урамшуулал олгох) болон оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;

2.2.2 Судалгааны үйл ажиллагааны хүрээнд магистрант, докторант оюутны эрдэм шинжилгээний ажлын чанар, үр дүнг сайжруулах, судалгааны ассистантшип (судалгааны сэдэвт ажил, төсөлд оролцуулж цалин урамшуулал олгох) хөтөлбөр хэрэгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, хэвлэн нийтлэх бодлогыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

2.2.3 Магистрант, докторант оюутанд хичээл заах, судалгааны ажлыг зөвлөж, удирдах, төсөл, сэдэвт эрдэм шинжилгээний ажил, инновацын үйл ажиллагаанд өргөн оролцуулах зэрэг профессорын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах;

2.2.4 Хөтөлбөрийн дагуу сургалт, судалгааны кредит цагийг чанартай биелүүлэх, судалгааны ажилд тасралтгүй оролцох, судалгааны ажлын үр дүнгээ хэлэлцүүлж, хэвлэн нийтлүүлэх, сургалт, судалгааны ассистантшип хөтөлбөрт хамрагдах зэрэг магистрант, докторант оюутны үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах;

2.2.5 Сургалт, судалгааны зардал, цагийн тооцоо, төлбөр, тэтгэлэгийн тооцоо, хуваарилалт, зарцуулалт болон оюутны судалгааг дэмжих санхүүжилт, тэтгэлэгийн сан бий болгох санхүү, эдийн засгийн үйл ажиллагааг зохион байгуулах.

Гурав. Удирдлага зохион байгуулалт

3.1 ТДС нь эрдмийн зөвлөл, захирал, ажилтнаас бүрдэнэ. Бүрэлдэхүүн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга нь төгсөлтийн дараах сургалтыг хариуцна. Бүрэлдэхүүн сургууль төгсөлтийн дараах сургалт хариуцсан ажилтантай байна.

3.2 ТДС-ийн эрдмийн зөвлөл нь бүрэлдэхүүн сургуулиудаас сонгогдсон профессоруудын төлөөллөөс бүрдэнэ. ТДС-ийн эрдмийн зөвлөл нь өөрийн журамтай байна.

3.3 ТДС-ийн захирал эрдмийн зөвлөлийн дарга байна.

3.4 Эрдэм шинжилгээ, сургалтын ажлыг чадварлаг зохион байгуулах туршлагатай, төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт оролцох шаардлагыг бүрэн хангасан МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн орон тооны профессор, дэд профессор эрдмийн зөвлөлийн гишүүнээр сонгогдох эрхтэй.

3.5 МУИС-ийн ТДС-ийн захирал нь дараах эрх/үүрэгтэй:

3.5.1 МУИС-ийн нэгдсэн бодлого, стратегийн хүрээнд үндсэн нэгжийн үйл ажиллагааг удирдах;

3.5.2 Үндсэн нэгжийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулан мөрдөж ажиллах;

3.5.3 Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавих, магадлан итгэмжлүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах;

3.5.4 МУИС-ийн магистрант, докторант оюутныг шилжүүлэх, улираах, хасах асуудлыг МУИС-ийн хэмжээнд нэгтгэн шийдвэрлүүлэх;

3.5.5 ТДС-ийг төлөөлж гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах гэрээ хэлцэл байгуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

3.5.6 Батлагдсан төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, ил тод мэдээлэх;

3.5.7 Эрдэм шинжилгээ, инновацын хэлтэс, Технологи дамжуулах төвтэй хамтран оюутны эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулах, сургалт-судалгааны нэгдлийг хангах;

3.5.8 Сургууль ба нийгмийн харилцаа холбоог уялдуулах, төгсөгчдийг ажлын байраар хангах, сургуулийг хөгжүүлэхэд төгсөгч, дэмжигчдийг татан оролцуулах.

Дөрөв. Төсөв, санхүү

4.1 ТДС-ийн үйл ажиллагааны зардал нь МУИС-ийн төвлөрсөн төсөвт жил бүр тусгагдана. Төсвийн зарцуулалтын эрх шилжүүлэх тухай асуудлыг МУИС-ийн захирлын тушаалаар зохицуулна.

4.2 ТДС нь магистрант, докторант оюутны сургалт, судалгааны ажлыг дэмжсэн тэтгэлэг, урамшууллыг олгох асуудлыг зохион байгуулна.

4.3 МУИС-ийн хэмжээнд төгсөлтийн дараах сургалтын санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны нэгдсэн бодлогыг боловсруулах, хэрэгжилтэнд хяналт тавьж, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна.

Тав. Номын сан, мэдээллийн бааз

5.1 Төгсөлтийн дараах сургалт явуулж буй хөтөлбөрийн чиглэлүүдээр мэргэжлийн болон электрон сэтгүүл захиалах, ном, сурах бичиг, интернет ашиглах боломжоор хангах, мэргэжлийн сэтгүүл, ном зүйн лавлагаа, нэг сэдэвт зохиол, эрдэм шинжилгээний цувралын сантай байх асуудлыг МУИС-ийн номын сан хариуцан ажиллана.

5.2 Номын сан нь магистрант, докторант оюутнуудад зориулсан уншлагын болон цахим мэдээллийн танхимтай байна.

5.3 Бүрэлдэхүүн сургууль нь магистрант, докторант оюутнуудыг интернэт байнга ашиглах боломжоор хангана.

Зургаа. Үндсэн үйл ажиллагаа

6.1 Хөтөлбөр шинээр нээх, хаах

6.1.1 МУИС нь сургалт, эрдэм шинжилгээний ажлын орчин нөхцлийг сайжруулах, профессорын судалгааны ажлыг хөхиүлэн дэмжих аргаар улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого баримтлана.

6.1.2 Профессорын эрдэм шинжилгээ, сургуулийн ажлын чадамж, туршлагад тулгуурлан, тодорхой мэргэжлийн болон мэргэжил дундын, салбар хоорондын, гадаад дотоодын их сургуулиудтай хамтарсан болон шинжлэх ухаан, үйлдвэрлэл, аж ахуй, төр захиргааны байгууллагын тусгай захиалгат хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр хэрэгжүүлнэ.

6.1.3 Хөтөлбөр шинээр нээхэд дараах дарааллыг баримтлана:

– Хөтөлбөрийг санаачлагч тэнхим хөтөлбөрийн эрэлт хэрэгцээ, профессор багшийн хүрэлцээ чадамж, хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг сайн судалж тогтоосон байна.

– Тэнхим нь хөтөлбөр нээх үндэслэл саналаа бүрэлдэхүүн сургуулийн захиргаа, эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрийг ТДС-ийн захиралд уламжлана.

– ТДС-ийн захирал эрдмийн зөвлөлөөрөө хэлэлцүүлэн, МУИС-ийн харгалзах асуудал хариуцсан дэд захирал, захирлын шийдвэрээр шинэ хөтөлбөр нээх хүсэлтийг БСШУЯ-нд уламжилж шийдвэрлүүлнэ.

6.1.4 Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээ, чанарын шаардлагатай уялдуулан хөтөлбөрийг хаах саналыг тэнхим, бүрэлдэхүүн сургууль, ТДС-ийн захирал гаргаж болно. Саналыг тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн захиргаа, эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж ТДС-д дүгнэлтийг хүргүүлнэ. ТДС эрдмийн зөвлөлөөрөө хэлэлцэж, шийдвэрээ МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.

6.2 Агуулга, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр

6.2.1 Магистрын сургалтын төлөвлөгөө нь 32 багц цагтай байна. Үүнд:

1. Магистрын эрдмийн зэрэг олгох сургалтын төлөвлөгөө:

Мэргэжлийн гадаад хэл	2 багц цаг
Судалгааны арга зүйн хичээл	2 багц цаг
Мэргэжлийн хичээл	9 багц цаг
Мэргэших хичээл	9 багц цаг
Эрдэм шинжилгээний ажил	4 багц цаг
Магистрын ажил	6 багц цаг

6.2.2 Салбар дундын болон мэргэжил дундын магистрын зэрэг олгох сургалтын төлөвлөгөө 32-40 багц цаг байх ба хөтөлбөрийн онцлог, хөтөлбөр хэрэгжүүлэх бүрэлдэхүүн сургуулиудын эрдмийн зөвлөлийн саналыг үндэслэн МУИС-ийн захирлын тушаалаар сургалтын төлөвлөгөөний багц цагийн хуваарилалтыг тогтооно.

6.2.3 Докторын сургалтын төлөвлөгөө нь мэргэжлийн хичээл 12, мэргэших хичээл 18 багц цаг, эрдэм шинжилгээний ажил 18 багц цаг, диссертац 12 багц цаг, нийт 60 багц цагийн бүтэцтэй байна. Мэргэжил болон хөтөлбөрийн онцлогоос хамааруулж сургалтын төлөвлөгөөний үзэх хичээл, эрдэм шинжилгээний цагийн харьцааг ТДС-ийн эрдмийн зөвлөлийн шийдвэрээр өөрчилж болох ба эрдэм шинжилгээний ажлын багц цаг 12 багц цагаас бага байж болохгүй.

6.2.4 Сургалтын төлөвлөгөөн дэх хичээл, эрдэм шинжилгээний ажлын багтаамж:

а). Судалгааны арга зүй хичээлд судалгааны аргууд, туршилтын үр дүнг боловсруулах, мэдээлэл хайх, боловсруулах, загварчлах, тоо баримт цуглуулах, компьютерээр боловсруулалт хийх, тооцоолох, монограф (нэг сэдэвт зохиол), өгүүлэл судлах, илтгэл тавих, өгүүлэл бичих г.м. асуудлуудыг тусгана.

б). Мэргэжлийн заавал үзэх хичээл нь шинжлэх ухааны тухайн салбараар судлаач хүний эзэмшсэн байх мэдлэгийн түвшний жишгийг тогтоосон агуулгатай байна.

в). Мэргэших хичээл нь нарийн мэргэжлээр судлаач хүний эзэмшсэн байх мэдлэгийн түвшний жишгийг тогтоосон агуулгатай байна. Удирдагч багшийн удирдлагаар бие даан судалж илтгэх, хичээлийн агуулгын зарим хэсгийг мэргэжлийн/удирдагчийн семинарт илтгэх, хэсэг бүлгээр хувааж реферат бичих, нөхцөлт судалгаа (case study) хийх, шалгалт өгөх хэлбэрээр багц цагаа тооцуулахыг зөвшөөрнө.

г). Суралцагч суралцаж буй чиглэлээсээ өөр 6 хүртэл багц цагийн хичээлийг сонирхлоороо сонгон судалж болно. Энэ нь мэргэших хичээлийн багц цагт багтна.

д). Сургалтын төлөвлөгөөний нэг багц цагийг бакалаврын сургалтын журамд заасны нэг адил тооцно.

е) Магистрантын эрдэм шинжилгээний багц цагийг эрдэм шинжилгээний төлөвлөгөөт семинар, их семинарт оролцсон, туршилт судалгаа хийсэн, судалгааны ажлын үр дүнг эрдэм шинжилгээний семинар, хуралд илтгэж хэлэлцүүлсэн, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, эрдэм

шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн зэргээр удирдагч үнэлж, тэнхим/профессорын баг баталгаажуулна. Магистрын ажлын багц цагийг магистрантын бичсэн магистрын ажил шаардлагыг бүрэн хангасан гэж удирдагч багш үзсэн тохиолдолд тооцно.

ё) Докторантын эрдэм шинжилгээний багц цагийг тооцохдоо эрдэм шинжилгээний төлөвлөгөөт семинар, их семинарт бүрэн суусан бол 0.1 багц цаг, өөрийн судалгааны ажлаа эрдэм шинжилгээний семинарт илтгэсэн бол 0.2 багц цаг, улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн бол 0.5 багц цаг, олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн бол 1.0 багц цаг, профессорын зөвлөлөөр зөвшөөрөгдсөн дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн бол 3.0 багц цаг, гадаадын нэр хүндтэй их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн бол 3.5 багц цаг, хянан магадлагаа бүхий гадаадын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн бол 5.0 багц цаг биелүүлсэнд тооцно. Ном, гарын авлага, сурах бичгээр багц цаг тооцохгүй.

6.2.5 Магистр, докторын сургалтын төлөвлөгөөг мэргэжил бүрээр бүрэлдэхүүн сургуулийн тэнхим боловсруулж, сургалтын нэгж хянан эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ. Эрдмийн зөвлөлийн хурлаар дэмжсэн бол ТДС-ийн захирал эрдмийн зөвлөлөөрөө хэлэлцүүлэн, МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна. МУИС-ийн ТДС-ийн боловсруулсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загварыг баримтлана.

6.2.6 Суралцагч бүр судлах хичээлийг улирлаар сонгож, бүрэлдэхүүн сургуулийн сургалтын нэгж хуваарь гарган баталгаажуулж, гүйцэтгэлийг хянаана. ТДС нэгдмэл хяналтыг хэрэгжүүлнэ.

6.2.7 Мэргэжлийн тэнхим сургалтын төлөвлөгөөн дэх хичээл бүрээр судлах агуулгыг боловсруулж, гүйцэтгэлийг хянаана.

6.2.8 Өдрөөр суралцагч нэг улиралд 12, эчнээгээр суралцагч 9-өөс ихгүй багц цагийн хичээл судална. Эрдэм шинжилгээний багц цагийн гүйцэтгэлд хязгаар тогтоохгүй.

6.2.9 Магистрант, докторант оюутны үзэх мэргэжлийн хичээлийн агуулга ижил байж, магистрант докторант хамт судалж болох бөгөөд тухайн мэргэжлээр үргэлжлүүлэн докторантурт суралцвал магистрын сургалтанд судалсан мэргэжил, мэргэшлийн хичээлийн багц цагийг докторын сургалтын мэргэжил, мэргэшлийн хичээлийн багц цагт тооцно. Магистрын, докторын хөтөлбөрт заавал судлах хичээлийг зааж болно.

6.2.10 Экстернат хэлбэрээр суралцах докторантын мэргэших хичээлийн 18 хүртлэх багц цагийг бүтээлүүдээр нь дүйцүүлэн тооцож болно. Дүйцүүлэн тооцож болох цагийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын томилсон комисс үнэлж, бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлөөр батлуулна. Дүйцүүлэн тооцож болох бүтээлд:

a) Үр дүн нь диссертацийн ажилд орохгүй, эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэн нийтлүүлсэн өгүүлэл,

c) Их сургуулийн сурах бичиг

d) Хэвлүүлсэн монографи,

e) Зохион бүтээсэн багаж төхөөрөмж, тогтоосон стандарт,

f) Байгуулсан эрдэм шинжилгээний лаборатори, эрдэм шинжилгээний музей,

g) Зарим боловсруулалтууд (компьютерийн программ, газрын зураг/карт, хуулийн төсөл, албан ёсоор улсын хэмжээнд мөрдөж буй аргачлал, стандарт г.м).

6.3 Элсэлт

6.3.1 Сургалт эрхлэх зөвшөөрөл авсан хөтөлбөрөөр магистрант, докторант оюутан элсүүлэх бөгөөд магистрын сургалтанд элсэгч тухайн мэргэжлээр бакалаврын, докторын сургалтанд элсэгч тухайн мэргэжлээр магистрын зэрэгтэй байна.

6.3.2 Элсэгч хэрэв өмнө эзэмшсэн бакалаврын ба магистрын мэргэжлээс өөр чиглэлээр магистрын ба докторын сургалтад хамрагдах бол сургалтын агуулгын залгамж чанарыг хангахад шаардагдах зөрүү гарсан хичээлийг нөхөн үзнэ. Нөхөн үзсэн хичээлийг магистрын зэрэг олгох үндсэн хичээлд хамааруулахгүй.

6.3.3 Элсэлтийг хичээлийн жилд хоёр удаа (2, 9-р сард) зохион байгуулна. ТДС элсэлтийг хариуцан зохион байгуулж, шинээр магистрант, докторантаар элсүүлэх тухай МУИС-ийн захирлын нэгдсэн тушаал гаргуулна.

6.3.4 Бүрэлдэхүүн сургууль бүр элсэхээр бүртгүүлсэн хүмүүсээс мэргэжлийн шалгалт авч холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, тэдгээрийн үнэн зөвийг магадлан, ярилцлага хийж элсүүлэх эсэх саналаа тогтоосон хугацаанд ТДС-д ирүүлнэ.

6.3.5 Магистрын сургалт нь өдөр, докторын сургалт өдөр, эчнээ, экстернат хэлбэртэй байна.

6.3.6 Дараах болзол хангасан хүнийг экстернат докторантаар суралцуулна. Үүнд:

- Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад сургалт, эрдэм шинжилгээний ажлыг 8-аас дээш жил хийсэн туршлагатай,

- Эрдэм шинжилгээ, сургалтын 15-аас доошгүй бүтээл хэвлэн нийтлүүлсэн, үр дүн нь диссертацид орохгүй бүтээлүүд нь мэргэжлийн ба мэргэшүүлэх хичээлүүдийн багц цагтай дүйцүүлэн тооцох боломжтой,

- Агуулга нь докторын диссертацийн 75 дээш хувийг хангахуйц бүтээл бичиж бэлэн болгосон

- Экстернатаар суралцахыг хүссэн хүний эрдэм шинжилгээний ажлын агуулга, чанар, үр дүнгийн талаар үнэлгээ өгч, бүтээлээр нь тооцох багц цаг тодорхойлж (6.2.10-р заалтыг баримтлан), суралцах болзол хангасан тухай бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлийн шийдвэр гарсан.

6.3.7 Гадаадын их сургуультай хамтарсан 1:1 хэлбэрийн сэндвич хөтөлбөр, докторын дараах сургалт, судлаач оюутан солилцох хөтөлбөр хэрэгжүүлж, МУИС төгсөгчдийн мэргэжил дээшлүүлэх сургалт явуулж болох ба хөтөлбөр боловсруулах, сургалтын агуулгыг тодорхойлох, оюутан сонгох, тэдний суралцах нөхцлийг хангах асуудлыг тусгай журмаар зохицуулна.

6.3.8 Гадаадын иргэнийг Засгийн газар хоорондын хэлэлцээр, сургууль хоорондын гэрээ, хувийн гэрээгээр магистрын ба докторын сургалтанд суралцуулна. Гадаадын иргэнийг элсүүлэхдээ МУИС-д гадаад оюутан элсүүлэх тусгай журмыг баримтлана.

6.4 Сургалтын хугацаа

6.4.1 Магистрын сургалтын ердийн хугацаа 2 жил, салбар болон мэргэжил дундын магистрын сургалтын ердийн хугацаа 2-2.5 жил, докторын сургалтын ердийн хугацаа өдрөөр суралцахад 3 жил, эчнээгээр суралцахад 4 жил, экстернат бол 1-2 жил байна. Судалгааны ажлыг тасралтгүй хийж, чанартай үр дүн гаргаж, багц цагаа бүрэн биелүүлсэн бол удирдагч, тэнхим, бүрэлдэхүүний сургууль, ТДС-ийн зөвшөөрлөөр магистрын сургалтын хугацааг хагас жилээр богиносгож болно.

6.4.2 Суралцагч суралцах хугацааг дүүргэснээр зэрэг горилсон магистрын ажил/докторын диссертац хамгаалах эрх нээгдэх бөгөөд хамгаалах эрхийн хугацаа 6.13.2-д заасан хугацаагаар хязгаарлагдана.

6.4.3 Сургалтын хичээлийн жил нь хоёр улиралтай, улирал тус бүр нь хичээлийн 16, шалгалтын 2, бүгд 18 долоо хоногтой байна. Хичээлийн жилийн улирал 10-р сарын 1 ба 3-р сарын 1-нээс эхэлнэ.

6.4.4 Мэргэжил өөрчилж суралцахтай холбоотойгоор судлах бэлтгэл сургалтын хугацааг судлах багц цагийн хэмжээнээс хамааруулж бүрэлдэхүүн сургуулийн захирлын шийдвэрээр тогтооно. Энэ хугацаа 2 улирлаас ихгүй байна.

6.5. Удирдагч, судалгааны ажлын сэдэв ба төлөвлөгөө

6.5.1 Магистрант, докторант оюутны удирдагч, хичээл заах багш докторын зэрэгтэй байна.

6.5.2 Магистрант, докторант оюутны элссэн улиралд багтаан мэргэжлийн тэнхим, профессорын баг, профессор, оюутны саналд тулгуурлсан бүрэлдэхүүн сургууль суралцагч нэг бүрээр эрдэм шинжилгээний ажлын удирдагчийг томилох саналыг боловсруулж ТДС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.

6.5.3 Мэргэжил дундын болон олон мэргэжил хоорондын хөтөлбөрөөр суралцагчийн удирдагчийг хөтөлбөрт оролцогч үндсэн нэгжүүдийн хамтын шийдвэрийг үндэслэн томилно.

6.5.4 МУИС-ийн магистр, докторын сургалтад идэвхитэй оролцдог, гадны байгууллагад судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхэлдэг, докторын зэрэгтэй хүн магистрант, докторантад хичээл зааж, удирдагчаар ажиллаж болно.

6.5.5 Удирдагч профессор нь магистрант, докторант оюутны судалгааны ажлын сэдэв, судалгааны ажлын төлөвлөгөөг чиглүүлэн тогтоож, биелэлтийг нь хянаж, туршилт хийх, задлан шинжлэх, туршилтын дүнг боловсруулах, өгүүлэл бичих, илтгэл тавих зэргийг удирдан чиглүүлэх үүрэгтэй. Удирдагч багш магистрын ажил, докторын диссертац бичихэд зөвлөн, түүний агуулга, чанар, судалгааны ажлын үр дүнгийн шинжлэх ухааны үнэн зөв байдал, хууль эрхийн хүрээнд хийгдсэн эсэхийг хянаж, удирдагчийн хувиар хариуцлага хүлээнэ.

6.5.6 Нэг профессор удирдах магистрант, докторантын тоог бүрэлдэхүүн сургуулийн онцлог, лабораторийн хүчин чадлаас хамааруулан бүрэлдэхүүн сургууль тогтоож болно.

6.5.7 Элсэх тушаал гарсны дараа суралцагч нь магистрын ажил/диссертацын сэдэв, сэдвийн дагуу судалгаа хийх төлөвлөгөөг удирдагчтай зөвшөлцөн боловсруулж, тэнхмийн эрхлэгч, сургалт хариуцсан нэгжээр хянуулан бүрэлдэхүүн сургууль, ТДС-ийн захирлаар батлуулна.

6.5.8 Магистрант, докторант оюутан хүндэтгэх шалтгаанаар удирдагч, сэдвээ өөрчлөх хүсэлт гаргавал холбогдох мэргэжлийн тэнхим, профессор, бүрэлдэхүүн сургуулийн саналыг үндэслэн ТДС-ийн захирал тушаал гаргаж шийдвэрлэнэ.

6.6 Мэдлэг, чадварыг үнэлж, дүгнэх

6.6.1 Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэхдээ "Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам"-ын 11.1, Бакалаврын журмын 17-р хэсгийн нэг адил мөрдөнө.

6.6.2 Суралцагч С буюу түүнээс дээш дүн авсан тохиолдолд тухайн багц цагийг биелүүлсэнд тооцно.

6.7 Судалгааны үр дүнг хэвлүүлэх

6.7.1 Докторантын хэвлүүлсэн бүтээлийг тооцож болох дотоодын мэргэжлийн сэтгүүлийн жагсаалтыг бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлийн саналыг үндэслэн ТДС-ийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж, МУИС-ийн захирлын тушаалаар батална.

6.8 Гадаад хэл

6.8.1 Магистрант, докторант оюутан хичээлээр авах багц цагийг биелүүлсний дараа англи хэлний шалгалт өгнө. Шалгалтыг ТДС-ийн захирлын тушаалаар байгуулсан гурваас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй комисс авна.

6.8.2 Магистрант, докторант оюутны англи хэлний шалгалтын агуулга, түвшнийг бүрэлдэхүүн сургууль мэргэжлийн тэнхим, гадаад хэлний сургалтын төвийн оролцоотой боловсруулж, МУИС-ийн ТДС-ийн захирлаар батлуулж мөрдөнө.

6.8.3 Гадаад хэлний шалгалтад хангалттай дүн авч чадаагүй суралцагч магистрын ажил, диссертац хамгаалалтанд орох эрхгүй.

6.8.4 Суралцагчдын мэргэжлийн англи хэлний мэдлэг чадвар нь мэргэжлийн харилцаанд бүрэн нийцэхүйц чансаатай байхыг шаардах бөгөөд тэдний англи хэлний мэдлэг, чадвараа дээшлүүлэх ажлыг ТДС санаачлан зохион байгуулна.

6.9 Магистрын ажил хамгаалах

6.9.1 Магистрын ажил нь тухайн шинжлэх ухааны тодорхой асуудлыг гүнзгийрүүлсэн судалгаа, туршилт, боловсруулалт, дүн шинжилгээ, онол арга зүйн зохих түвшинд гүйцэтгэж, тухайн асуудлын шинжлэх ухааны үндэслэл, онол практикийн дүгнэлт зэрэг үр дүнд хүрсэн эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл байх шаардлагыг хангасан байна.

6.9.2 Магистрын ажлын хамгаалалтын өмнөх хэлэлцүүлгийг тэнхим/профессорын багийн эрдэм шинжилгээний өргөтгөсөн семинарт хийнэ. Өргөтгөсөн семинараас дүгнэлт гаргаж, хуралдааны протоколын хамт бүрэлдэхүүн сургуулийн сургалтын нэгжид хүргүүлнэ. Семинарын товыг нийтэд зарлаж, нээлттэй хийнэ.

6.9.3 Магистрын ажлыг МУИС-ийн захирлын тушаалаар баталсан загвар, шаардлагын дагуу бичиж хэвлүүлнэ.

6.9.4 Магистрын ажлыг магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлд хамгаална. Зэрэг хамгаалуулах зөвлөлийг бүрэлдэхүүн сургуулийн саналыг үндэслэн ТДС-ийн захирлын тушаалаар байгуулна. Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийг БСШУ-ны сайдын баталсан “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-ийн дагуу байгуулах ба тус зөвлөл нь энэхүү дүрмийн хүрээнд ажиллана.

6.9.5 Магистрант сургалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, гадаад хэлний шалгалтаа өгсөн, сургалтын төлбөрөө төлсөн, магистрын ажлаа тэнхим/профессорын багд урьдчилан хэлэлцүүлсэн тухай бүрэлдэхүүн сургуулийн дүгнэлтийг үндэслэн, магистрын зэрэг хамгаалуулахыг зөвшөөрсөн тухай ТДС-ийн захирлын тушаал гаргаж, магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлд уламжлана.

6.9.6 Магистрын ажлаа хамгаалж чадаагүй бол 2 жилийн дотор дахин нэг удаа хамгаалуулах зөвлөлд хэлэлцүүлэх эрхтэй. Дахин хамгаалалтанд орох хүсэлтээ бүрэлдэхүүн сургуулийн захиралд гаргах ба бүрэлдэхүүн сургуулийн саналыг үндэслэн МУИС-ийн захирлын тушаалаар зөвшөөрөл олгоно.

6.10 Докторын диссертац хамгаалах

6.10.1 Докторын диссертац нь тухайн мэргэжлийн салбарын мэдлэгт холбогдол бүхий зорилтыг шийдсэн, эсвэл улс орны нийгэм, эдийн засагт холбогдолтой практик асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй (арга, аргачлалын дагуу нотлон)-гээр шийдсэн, урьд өмнө хийгдсэн мэдэгдэж буй бусад шийдлүүдтэй харьцуулж, бүтээлчээр шинэлэг талыг нээн харуулсан, тухайн сэдвээр шинэ мэдлэг мэдээлэл, үндэслэл, онол практикийн дүгнэлт гаргасан эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл байх шаардлагыг хангасан байна.

6.10.2 Докторант сургалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, гадаад хэлний шалгалтаа өгсөн, сургалтын төлбөрөө төлсөн, диссертацийн ажлаа тэнхим/профессорын баг, бүрэлдэхүүн сургуулийн өргөтгөсөн семинарт урьдчилан хэлэлцүүлсэн тухай МУИС-ийн ТДС дүгнэлт гарган докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд уламжлана.

6.10.3 Докторын зэрэг горилсон диссертацийн урьдчилсан хэлэлцүүлгийг бүрэлдэхүүн сургуулийн мэргэжлийн эрдэмтдээр өргөтгөсөн их семинарт хийнэ. Семинарын товыг нийтэд зарлаж, нээлттэй хийнэ. Семинараас диссертацид мэргэжлийн дүгнэлт хийж, хуралдааны протокол гаргах ба энэ нь докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд МУИС-иас гаргаж өгөх дүгнэлтийн нэг үндэслэл болно.

6.10.4 Докторын диссертацыг МУИС-ийн захирлын баталсан загвар, шаардлагын дагуу бичиж, хэвлүүлнэ.

6.10.5 Докторын диссертацаа хамгаалж чадаагүй бол 3 жилийн дотор дахин нэг удаа хамгаалуулах зөвлөлд хэлэлцүүлэх эрхтэй. Дахин хамгаалалтанд орох хүсэлтээ докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн даргад гаргаж шийдвэрлүүлнэ.

6.10.6 Диссертацыг монгол хэлээр бичнэ. Диссертацын тухай товч танилцуулгыг англи хэлээр 3 хуудаст багтаан бичиж, диссертацын эцэст хавсаргана. Горилогчийн хүсэлт, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн дийлэнх олонхийн зөвшөөрснөөр диссертацын ажлыг англи хэлээр бичүүлж, хамгаалалтыг англи хэлээр явуулж болно. Энэ тохиолдолд диссертацын тухай товч танилцуулгыг монгол хэлээр бичнэ.

6.11 Магистрын ажил, докторын диссертац тушаах

6.11.1 Зэрэг хамгаалсан магистрант, докторантын талаар хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь дараах материалыг бүрдүүлэн ТДС-д ирүүлнэ. Эдгээр материалыг дипломын хуулбарын хамт сургуулийн архив болон номын санд хадгална. Үүнд:

а) Дэлгэрэнгүй анкет (1-р маягт),

б) Хамгаалуулах зөвлөлийн хуралдааны протокол, тогтоол,

в) Удирдагчийн тодорхойлолт,

г) Зохих шаардлагыг ханган бүрэн эцэслэсэн, удирдагч, хамгаалуулах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурсан магистрын ажил, докторын диссертац, түүний CD бичлэг 2 хувь

д) Тооцоо хийсэн тойрох хуудас

6.11.2 Магистрын ажил, диссертацын хувийг Үндэсний номын сан, Мэдээллийн технологийн үндэсний парк, түшиглэсэн болон суралцагчийн суралцсан сургуулийн номын санд хүлээлгэн өгнө.

6.12 Магистр, докторын зэрэг олгох

6.12.1 Магистрын ажил болон докторын диссертацийг амжилттай хамгаалсныг баталсан эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн МУИС-ийн захирлын тушаалаар магистр/докторын зэрэг олгох шийдвэр гаргана. Энэхүү шийдвэрийг үндэслэн ТДС магистр/докторын зэрэг олгосон дипломыг бичиж, гардуулах ажлыг зохион байгуулна.

6.13 Төгсөлт, шилжилт хөдөлгөөн

6.13.1 Хичээлийн жилд 2 удаа 6, 2-р сард магистр, докторын зэрэг олгох төгсөлтийг хийнэ.

6.13.2 Магистрант, докторант оюутан сургалтын бүх багц цагаа хугацаандаа цуглуулсан боловч магистрийн ажил, диссертац бичих багц цагаа биелүүлж амжаагүй бол МУИС-ийн магистр/докторын сургалт дүүргэсэн тухай захирлын тушаал гаргаж, гэрчилгээ олгоно. Магистрант оюутны сургалтын багц цаг энэхүү гэрчилгээг авснаас хойш 3 жил, докторант оюутны сургалтын багц цаг энэхүү гэрчилгээг авснаас хойш 5 жил хүчинтэй байх ба энэ хугацаанд эрдэм шинжилгээний багц цагаа гүйцээн магистрын ажил, докторын диссертац бичиж хамгаалах эрхтэй байна.

6.13.3 Магистрант, докторант оюутан албан ёсны зөвшөөрөлгүйгээр нэг хичээлийн жилд сургалт, судалгааны ажилд ороогүй, сургалтын төлбөрөө төлөөгүй бол түүнийг сургуулиас хасна.

6.13.4 Магадлан итгэмжлэгдсэн, ТДС-ийн эрдмийн зөвлөл багц цагийг нь хүлээн зөвшөөрсөн их сургуульд амжилттай суралцаж байгаа магистрант, докторантыг өөрийн нь хүсэлт, профессор, мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүн болон ТДС-ийн сургуулийн зөвшөөрлийг үндэслэн шилжүүлэн авч болно.

6.13.5 Гадаадын нэр хүндтэй их сургуульд суралцаж авсан магистрант оюутны 10 хүртэл, докторант оюутны 20 хүртэл, дотоодын их сургуульд суралцаж авсан магистрант оюутны 6 хүртэл, докторант оюутны 9 хүртэл багц цагийг тус тус тооцож болно.

6.14. Сургалтын төлбөр, тэтгэлэг, ассистантшип (хичээл заах болон судалгааны сэдэвт ажил, төсөлд оролцуулж цалин урамшуулал олгох)

6.14.1 Удирдах зөвлөлөөр батлагдсан тухайн жилийн багц цагийн үнэлгээгээр бодогдох тухайн жилд судласан нийт багц цагийн төлбөрийн нийлбэрийг тухайн жилийн сургалтын төлбөр гэж тооцно.

6.14.2 Суралцагч төлбөрийг улирал, жилээр төлж болох ба энэ тухай бүрэлдэхүүн сургуулийн захиргаатай байгуулах гэрээнд нарийн тусгана.

6.14.3 Суралцагч сурлага, сахилгаар хасагдах болон хүсэлтээрээ чөлөөлөгдөх үед улс, захиалагч байгууллагаас төлсөн зардлыг буцааж төлөх болбол түүнийг суралцагч өөрөө хариуцна.

6.14.4 Суралцагч нь суралцах хугацаандаа сургуулийн дотоод журмын хүрээнд МУИС-ийн номын сан, компьютерийн болон эрдэм шинжилгээний лаборатори, холбогдох судалгаа шинжилгээний багаж хэрэгслийг ашиглах эрхтэй.

6.14.5 Сургуулиас үзүүлэх нэмэлт үйлчилгээтэй холбоотой бүх төрлийн төлбөр, хураамжийн талаарх журмыг МУИС-ийн санхүү, эдийн засгийн албанаас тухайн хичээлийн жил эхлэхээс өмнө гарган мөрдүүлнэ.

6.14.6 Докторантаар хичээл заалгах, магистрантыг хичээл сургалтанд оролцуулах, магистрант, докторантын төлбөрийг хөнгөлөх, тэтгэлэгт хамруулах, профессорын гүйцэтгэж байгаа эрдэм

шинжилгээний сэдэвт ажил, төсөлд магистрант докторантыг ажиллуулж судалгааг санхүүжүүлэх чиглэлээр удирдагч багш, профессорын баг/тэнхим, сургууль санаачлагатай ажиллах үүрэг хүлээнэ.

6.14.7 Зохих шалгуур хангасан суралцагч сургалтын төлбөрийн тэтгэлэг, зээлд хамрагдах ба хичээл заах, сургалтанд оролцох, судалгааны төсөлд хамрагдах замаар (ассистантшип) цалинжих боломжийг МУИС тусгай журмаар зохицуулна.

6.14.8 Докторантын диссертац хамгаалахтай холбогдох зардлыг сургалтын төлбөрт оруулахгүй, зөвхөн хамгаалах болсон нөхцөлд диссертацын 12 багц цагийн төлбөрийг төлнө. Энэ нь хамгаалахтай холбоотой зардалд зарцуулагдана.